



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 21 өдөр

Дугаар #/29

Булган сум

Физикийн бүсийн олимпиадыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны “Олимпиад зохион байгуулах журам” батлах тухай А/420 дугаар тушаалын 3.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Гавьяат багш, шатрын спортын мастер Ж.Пүрэвсүрэнгийн нэрэмжит “Хойд бүс IV” физикийн олимпиадыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: М.Солонго (Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)
Д.Дэжидбаа (Боловсролын газрын Математик, мэдээллийн технологийн боловсрол хариуцсан ахлах арга зүйч)

Я.Нямсүрэн (Боловсролын газрын Биеийн тамирын боловсрол хариуцсан ахлах арга зүйч)
Б.Оюунсууд (Булган сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн захирал)

Э.Түвшинмөнх (Булган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн захирал)

Нарийн бичгийн дарга: Б.Мөнхгэрэл (Боловсролын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2. Олимпиадыг хууль, журмын дагуу үр дүнтэй зохион байгуулахыг Ажлын хэсэг (М.Батчимэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Энэгээс Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

635510044

доносблысэн